



21 АЙМГИЙН ОРОН  
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,  
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: info@pcsp.gov.mn,  
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2020.04.01 № А-1/510  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т


**Чиглэл өгөх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байгаа тээврийн хэрэгсэл нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.3 дахь заалтад дурдсан баримт, мэдээллийг бүрдүүлэн холбогдох хуулийн хүрээнд төлбөр, татвар хураамжийг цаг тухайд нь төлсөн байх ёстой.

Иймд тээврийн хэрэгсэлтэй холбоотой материалын бүрдлийг бүрэн хангаж шийдвэр гаргаж байх, шийдвэрийн биелэлтийг хүлээн авахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 8.5, 8.6 дахь заалтын дагуу акталсан, шилжүүлсэн, худалдсан тээврийн хэрэгслийн улсын дугаарыг “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийн хамт ирүүлнэ гэсэн заалтыг шийдвэрт тусгаж байх нь зүйтэй байна.

Үндсэн хөрөнгөөс хасах шийдвэр гарч хэрэгжсэн боловч “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын улсын нэгдсэн мэдээллийн системээс хасалт хийлгээгүй байгаа тээврийн хэрэгслийн төлбөр тооцоог тухайн тээврийн хэрэгслийг эзэмшигч хариуцах бөгөөд ийнхүү гаргасан зөрчил дутагдал нь татвар, төлбөрөөс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй юм.

ДАРГА



З.МЭНДСАЙХАН